91

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

15160 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Баянгол 44, Засгийн газрын 4 дэвхар
Утас: 263-27-27, и-мэйл: info@mecs.gov.mn
Вэб хаяг: www.mecs.gov.mn

2024.08.16 № 1а/480

танай _____ -ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас 2023-2024 оны хичээлийн жил эхлэх гэж байгаатай холбогдуулан тавьсан асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу хүргүүлж байна. Үүнд:

Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/01 тушаалаар батлагдсан хичээлийн жилийн бүтцийн талаар:

1.1. 2023-2024 оны хичээлийн жилийн бүтэц 4 улиралтай байсныг 3 улиралтай болгох шийдвэр гаргажээ. Энэхүү бүтцээс харахад хичээлийн жилийн 1-р улирал 1-2-р ангид 16, 3-9-р ангид 17, 10-12-р ангид 18 долоо хоног байхаар тооцсон нь суралцагчид залхах, багш, сурагчгүй ядрах, хичээллэх хүсэл сонирхол буурдгийг өмнөх жилүүдийн туршлага харуулсаар байтал энэхүү шийдвэрийг гаргах болсны үндэслэл, шалтгааныг тайлбарлана уу?

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ, 5.3-т "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч хичээлийн жилийн хугацаанд 170-185 хоног хичээллэнэ" гэж тус тус заасан. Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/350, А/398 дугаар тушаалаар сургалтын төлөвлөгөөг 34-37 долоо хоног хичээллэхээр батлсан. Энэхүү хугацаанд нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг:

- 1-2 дугаар анги 34,
- 3-4 дүгээр анги 35,
- 6-9 дүгээр анги 36,
- 10-12 дугаар анги 37 долоо хоног хичээллэхээр төлөвлөсөн тул зуны улирлаас бусад завсрын амралтад 4-6 долоо хоног ноогдож байна.

Иймд дээр дурдсан 4-6 долоо хоногийн амралтыг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад өвлийн ид хүйтрэлт, томуу, томуу төст өвчний дэгдэлт ихэсдэг 12 дугаар сарын сүүлээс 1 дүгээр сарын дунд үеийг дуустал 3-5 долоо хоног, хаврын амралтыг нэг долоо хоног байхаар, аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн өвлийн амралт 2-4 долоо хоног, хаврын амралтыг мал төллөх хугацаатай уялдуулан 2 долоо хоног байхаар тус тус төлөвлөсөн болно.

Дөрвөн улиралтай хичээлийн жилийн бүтэц хэрэгжиж байх үед хэт хүйтрэлт, агаарын бохирдол, томуу, томуу төст, халдварт өвчний тархалтын нөхцөл байдлыг харгалзан хичээлийн жилийн дундуур амралт, хичээлийн хугацаанд өөрчлөлт

тохируулга хийх шаардлага үүсдэгийг өмнөх жилүүдийн туршлага харуулсаар ирсэн билээ. Ингэснээр багш, сургалтын байгууллагын төлөвлөсөн сургалт, үйл ажиллагаа тодорхой хугацаагаар хойшлох, тасалдах, хичээл сургалтын зохион байгуулалтад гэнэтийн өөрчлөлт оруулснаар багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл зүйд сөрөг үр дагаврыг дагуулж байсан.

Нэгдүгээр улирал 16-18 долоо хоног үргэлжилж байгаа хэдий ч хичээлийн жилийн 9 дүгээр долоо хоног зохион байгуулах бие даалтын үйл ажиллагааг орон нутаг, сургуулийн онцлогт нийцүүлэн танхимын болон танхимын бус, уян хатан хэлбэрээр зохион байгуулснаар суралцагчдын оюуны ачааллыг бууруулах боломжтой гэж бид үзсэн.

1.2. Хичээлийн жилийн 1-р улирлын дундуур буюу 9 дэх долоо хоногт Бие даалтын үйл ажиллагааг тавьснаар ямар үр дүн гарна гэж тооцоолж байгаа вэ? Энэ хугацаанд 1-р улирлын амралтыг зохион байгуулж, хичээлийн жилээ 4 улиралтай байхаар тооцоолж болоогүй юм уу? Бие даалтын үйл ажиллагаа нь Боловсролын ерөнхий хуулийн 8.1, 8.2-т заасан сургалтын хэлбэрийн аль хэсэгт хамаарах вэ?

1.3 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт "Холбогдох хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.2-т заасан танхимын бус хэлбэрээр зохион байгуулна." гэж заасан байхад хууль зөрчин, 1-р улирлын 18 дахь долоо хоногт ахлах ангийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна гэсний шалтгаан юу вэ?

1.4. 2025 оны билгийн тооллын цагаан сарын шинийн нэгэн 3-р сарын 1-ний өдрийн бямба гаригт тохиож байгаа. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт зааснаар цагаан сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүд нийтээр тэмдэглэх баярын өдөр тул амарна. Иймд ёс уламжлал, нөхцөл байдлаа тооцоод 1 долоо хоногийн амралт зохион байгуулах боломж бий юу?

1.2, 1.3, 1.4 хэсэг дэх асуултад доорх хэсэгт нэгтгэн хариулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр шинэчлэгдээгүй, агуулгын багтаамж хэвээр мөрдөгдөж байгаа бөгөөд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд зааснаар хичээлийн жилийн үргэлжлэх хугацаа уртассан тул ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлийн цагийг хэвээр хадгалж, хичээлийн жилийн бүтцэд бие даалтын цаг оруулах боломж бүрдсэн.

Иймд хичээлийн жилийн 9 дэх долоо хоног, 31 /аймаг, сумын ЕБС-д 30 дахь/ дэх долоо хоногт долоо хоногт тус тус суралцагчдын хувь хүний хөгжил, бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг эцэг эх асран хамгаалагчдын хамтын ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.

Энэхүү бие даалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.1, 8.2-т заасан хэлбэрийг хослуулан, орон нутаг, сургуулийн онцлогт нийцүүлэн уян хатан хэлбэрээр зохион байгуулна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5.7-д заасан "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.2-т заасан танхимын бус хэлбэрээр зохион

байгуулна" гэж заасан бөгөөд бусад тохиолдолд сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулахыг энэ хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хориглоогүй.

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.6-д "сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах"-ыг боловсролын сургалтын байгууллагын удирдлагын чиг үүрэгт заасан. Цаашид техник, технологид суурилсан, сургалтын уян хатан хэлбэрийг бүх түвшний сургалтад хэрэгжүүлж, багш, суралцагчдын цахим ур чадварыг хөгжүүлэх, бүх насны иргэдэд хувь хүний ялгаатай хэрэгцээ, онцлогт нийцсэн хувилбарт сургалтуудыг санал болгох хэрэгцээ, шаардлагатай байна.

Иймд хичээл, сургалтыг танхимын болон танхимын бус, цахим, зайн, хосолсон сургалтын хэлбэрээр зохион байгуулах хуулийн заалтын дагуу ахлах ангийн нэг долоо хоногийн хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар хичээлийн жилийн бүтцэд оруулсан болно.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан хичээлийн жил эхлэх, дуусах, үргэлжлэх хугацаа болон энэхүү тайлбар бичгийн 1.1-д дурдсан өвлийн улирлын амралтыг байгаль, цаг уур, орон нутгийн онцлогт нийцүүлсэн зохицуулалтаас хамааран холбогдох хуульд заасан нийтээр амрах амралтын өдрүүд дээр нэмж амралт зохион байгуулах боломжгүй.

1.5. VI-XII ангийн суралцагчдын хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг 36, 37 долоо хоног байгааг 35 болгон, 6-р сарын эхний долоо хоногт багтаан хичээлийн жилийг дуусгах талаар арга хэмжээ авч болох эсэх.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ, 5.3-т "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч хичээлийн жилийн хугацаанд 170-185 хоног хичээллэнэ" гэж заасан тул дунд, ахлах ангийн хичээллэх долоо хоногийг 35 болгох, 6 дугаар сарын эхний долоо хоногт хичээлийн жилийг дуусгах боломжгүй болно.

2.Багш мэргэжлийн зэрэг олгох журам шинэчлэгдэн гарахгүй байгаа талаар:

2.1.Багшийн мэргэжлийн зэрэг олгох журмыг хэзээ шинэчлэн гаргах вэ?

Боловсролын ерөнхий хуулийн 26.1.2-т заасан "Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтанд мэргэшлийн зэрэг олгох журам"-ын төслийг боловсруулан холбогдох талуудаа санал авч тусгах ажлыг зохион байгуулж байна. Энэхүү журмыг 2024 оны 08 дугаар сард багтаан баталж, Захиргааны ерөнхий хуулийн 65.1-д заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

.Өмнөх журам хүчингүй болсноос хойш шинэчлэгдэн гарах хүртэлх хугацаанд мэргэжлийн зэргээ шинээр авч, эсвэл сунгаж чадаагүй багш нарын хохирлыг хэрхэн барагдуулах вэ?

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалаар баталсан "Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам"-ын дагуу 2023 онд арга зүйч, тэргүүлэх мэргэжлийн зэргийн шаардлага хангасан багш нарт

мэргэжлийн зэргийг журам хүчинтэй байх хугацаанд олгож, журмын 4.1-д "Мэргэжлийн зэрэг шинээр олгосон багш, ажилтанд нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгоно." гэсний дагуу 2024 онд холбогдох нэмэгдлийг олгож байна.

Харин тус журмын 3.11-д заасны дагуу 2023 онд зөвлөх багш мэргэжлийн зэргийн шалгуурыг магадлан шалгасан дүгнэлтийг үндэслэн тус журмын 3.13-д заасан шийдвэрийг гаргах үйл ажиллагааг журмын хүчинтэй хугацаанд зохион байгуулаагүй байна. Иймд тухайн онд журмын хүчин төгөлдөр хугацаанд зөвлөх багшийн мэргэжлийн зэргийн шаардлага хангасан багш нарт мэргэжлийн зэрэг, нэмэгдэл хөлсийг нөхөн олгуулах тусгайлсан зохицуулалт хийхээр ажиллаж байна.

Мөн 2024 оны мэргэшлийн зэргийн материал хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг 2024 оны 9-11 дүгээр саруудад зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

3.Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ээлжийн амралтыг хуваан эдлүүлэх чиглэлийн талаар

3.1. Боловсролын сайдын шууд үүрэгжүүлсэн чиглэлээр багш, ажилтны ээлжийн амралтыг ингэж хэсэгчлэн хуваахад Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.8-д заасан "Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын үргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна." гэсэн заалт зөрчигдөх үү?

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ээлжийн амралт нь Хөдөлмөрийн тухай хууль болон Боловсролын ерөнхий хуульд зааснаар ажлын 48 өдөр байна. Хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанаас хамааран багш нь ээлжийн амралтаа зуны улиралд бүтэн эдлэх хоног хүрэлцэхгүй байх, хичээлийн жилийн бэлтгэл хийх хугацаагүйгээр ажилдаа тулгаж орох асуудал үүсдэг. Мөн сурагчдын өвлийн амралтын үеэр гэр бүлтэйгээ амрах хүсэлтэй багш нар цөөнгүй байдаг. Энэ тохиолдод ээлжийн амралтын нэгдүгээр хэсгийн үргэлжлэх хугацаа 5, хоёр дахь хэсгийн тасралтгүй үргэлжлэх хугацаа 43 ажлын өдөр байх тул Хөдөлмөрийн тухай хуулийн 99.8-д "Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын үргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна." гэсэнд нийцэж байна.

3.2. Чиглэлд дурдагдсан ээлжийн амралтын эхний 5 хоногийг хэсэгчлэн эдлэх 2025 оны 1-р сарын эхний долоо хоног нь хуулиараа ажлын өдрүүд байгаа. Хэрвээ энэ өдрүүдэд ээлжийн амралтаа хэсэгчлэн эдэлсэн тохиолдолд ажилласнаар тооцож цалингаа олгох уу эсхүл ээлжийн амралт эдэлснээр тооцож ээлжийн амралтын цалин олгох уу? Зуны амралтаар эдлэх үлдсэн 43 хоногийн амралтын цалин 48 хоногоор бодогдох уу? Багш, ажилтнуудад ямар ашигтай хийгээд хохиролтой нөхцөл байдал үүсэж болох вэ? Үүн дээр гаргасан тооцоо, судалгаа байна уу?

Багшийн өөрийн хүсэлтийг харгалзан ээлжийн амралтын 5 өдрийг тухайн оны эхний сард биеэр эдлүүлэхэд жилд ноогдох 48 хоногийн ээлжийн амралтын олговор, тухайн сарын цалингийн хэмжээнд нөлөөлөхгүй. Багш өөрийн хүсэлтээр ээлжийн амралтаа хэсэгчлэн эдлэх тул багшийн эрх ашиг хохирох асуудал гарахгүй юм.

3.3. *Багш, ажилтны ээлжийн амралтыг хуваж эдлүүлэх талаар багш, ажилтнуудаас саналыг нь авсан уу? Авсан бол ямар дүгнэлт гарсан бэ?*

Багшийн ээлжийн амралтыг хуваан эдлүүлэх талаар багш тус бүрийн өөрийн саналд үндэслэн шийдвэрлэнэ.

3.4. *2024-2025 оны хичээлийн жил дуусах хугацааг 6-р сарын дунд хүртэл тооцохоор багш, ажилтны ээлжийн амралтыг хуваж, тэдний эрх ашгийг зөрчих нөхцөл үүсэж байгааг ойлгож байна уу? Асуултын 1 дэх хэсэг болон энэ хэсгийн нөхцөл байдлыг тооцоолоод хичээлийн жилийн бүтцээ эргэн харж, уян хатан зохицуулалт хийж болохгүй байгаа юм уу?*

Хичээлийн жилийн эхлэх, дуусах, үргэлжлэх хугацааг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5.1-т "Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ." гэж тодорхой заасан тул багшийн ээлжийн амралтаас хамааран эхлэх дуусах хугацааг өөрчлөх боломжгүй.

4. 2024-2025 оны хичээлийн жилд үүсэж буй багш, ажилтны хомсдолын талаар:

4.1. Аль сургууль, цэцэрлэг, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад ямар мэргэжлийн хэдэн багш, ажилтан дутагдалтай байгаа талаар дэлгэрэнгүй судалгаа байна уу.

Судалгаагаар 2024-2025 оны хичээлийн жилд:

- Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад 508 үндсэн багш (үүнээс орон нутагт 204, нийслэлд 304), 443 багшийн туслах (үүнээс орон нутагт 97, нийслэлд 346) , 122 арга зүйч (үүнээс орон нутагт 67, нийслэлд 55), 27 цэцэрлэгийн эрхлэгч (үүнээс орон нутагт 25, нийслэлд 2) дутагдалтай байна (Хавсралт 1).

Багш, ажилтны сул орон тооны мэдээллийг Боловсролын ерөнхий газрын Facebook-ийн page хуудсанд байршуулсан.

- Ерөнхий боловсрол: Ерөнхий боловсролын сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 4292 багш, үүнээс нийслэлд 1723, орон нутагт 3575 багш шаардлагатай гэсэн судалгаа гарсан. Судлагдахуунаар авч үзвэл бага анги 752, англи хэлний багш 550, математикийн багш 411, монгол хэлний багш 305, дутагдалтай байна (Хавсралт 2).

- Мэргэжлийн болон техникийн боловсрол: 2024 оны 8 сарын 17-ны байдлаар мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 39 мэргэжлийн багш, 43 ерөнхий эрдэм, нийт 82 багш дутагдалтай байна.

4.2. дутагдалтай багш, ажилтныг нөхөх талаар ямар арга хэмжээнүүд төлөвлөж байна вэ?

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 192 дүгээр тогтоолоор "Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ батлагдан хэрэгжиж эхэлсэн. Бодлогын зорилго нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байгаа болно.

Засгийн газраас хэрэгжүүлж буй цогц арга хэмжээний хүрээнд:

- Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн 326 дугаар тогтоол, 2024 оны 03 дугаар сарын 06-ны 103 дугаар тогтоолын дагуу Магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр, багш нарыг магистрын болон гадаад, дотоодод мэргэшүүлэх сургалтад суралцуулах,


- Нөөцөд байгаа багш (тэтгэвэрт гарсан, багш мэргэжлээрээ ажиллахгүй байгаа, багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын 3, 4 дүгээр ангийн суралцагчдыг дадлагажигч багшаар ажиллуулах зэрэг)-ийг ажиллуулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбоотойгоор багшийн мэргэжлээс бусад мэргэжилтэй иргэнд багшлах эрх олгох харилцааг зохицуулсан журмын төслийг боловсруулан батлуулахад бэлэн болгоод байна.

Журмын төсөлд сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад ажиллах хүсэлтэй багшийн мэргэжлээс бусад мэргэжилтэй иргэнийг хувилбарт сургалтаар бэлтгэхээр тусгаад байна. Ингэхдээ дутагдалтай байгаа математик болон байгалийн шинжлэх ухаан, анагаах ухаан, мэдээлэл харилцаа, технологи, хууль, бизнес, эдийн засаг, урлаг, англи хэлний чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагыг 2.7-оос доошгүй голч дүнтэй төгссөн, бакалаврааас доошгүй зэрэгтэй болон эдгээр чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад 2.7-оос доошгүй голч оноотой суралцаж байгаа гурав, дүгээр ангийн суралцагч багшлах эрхийн хувилбарт сургалтад хамрагдах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн.

Цаашид их өгөгдөлд суурилсан багшийн хүртээмж, чанарын бодлого, төлөвлөлт хэрэгжүүлнэ. Энэ ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багшийн data analytic системийн хөгжүүлж эхлээд байна.

Зураг 1. Дата аналитикийн системийн нүүр хуудас



4.3.сүүлийн 4 жилийн (2020-2021, 2021-2022, 2022-2023, 2023-2024 оны хичээлийн жилүүд)-ийн дутагдалтай байсан багш, ажилтны тоо, тэдгээрийг хэрхэн нөхөж ирсэн талаар дэлгэрэнгүй судалгаа байна уу? Байгаа бол бичгээр явуулна уу?

"Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030" (2020)-ийн хүрээнд хийсэн судалгаагаар одоо хүн амын өсөлтөд үндэслэн ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай багшийг тооцоолоход 2025 он гэхэд 23,576 багшийг нэмж ажилд авах хэрэгцээ үүсэж байна. Энэхүү тооцоог одоо хэрэгжиж буй ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө болон нэг ангид сурах хүүхдийн тоог 35-аас хэтрэхгүй байх тооцоонд үндэслэн гаргасан.

Хүснэгт 1. Хүн амын өсөлтөд үндэслэн ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай багшийг тооцоолол хийсэн байдал

№	Хичээл	2018			2023		2025		2030	
		Одоо	Нийт	Нэмэлт	Нийт	Нэмэлт	Нийт	Нэмэлт	Нийт	Нэмэлт
1	Бага анги	10397	10759	362	11727	1590	12265	3428	12696	5158
2	Монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг	2654	3370	716	3808	1220	5457	3001	5762	3838
3	Математик	2363	2425	62	2740	436	3783	1774	4147	2433
4	Мэдээллийн технологи	705	703	-2	795	107	1097	498	1203	691
5	Физик	998	1137	139	1285	312	1774	925	1944	1221
6	Биологи	844	1137	293	1285	462	1774	1156	1944	1332
7	Хими	739	1137	398	1285	564	1774	1145	1944	1408
8	Газарзүй	602	758	156	856	269	1182	671	1296	860
9	Түүх	634	954	320	1078	460	1488	949	1631	1171
10	Нийгэм судлал, Иргэний боловсрол	1106	1716	610	1939	861	2677	1737	2934	2133
11	Дүрслэх урлаг, Зураг зүй, Технологи	1943	2684	741	3033	1139	4187	2536	4590	3181
12	Дуу хөгжим	1080	1413	333	1597	544	2204	1286	2416	1633
13	Биеийн тамир	2042	2308	266	2608	617	3601	1865	3947	2467
14	Эрүүл мэнд	345	813	468	919	583	1269	976	1391	1141
15	Англи хэл	2766	2341	-425	2646	-51	3653	1301	4004	1998
16	Орос хэл	720	667	-53	754	52	1041	429	1141	619

Түүнчлэн Үндэсний статистикийн хороотой хамтран 2022 онд хийсэн ""Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод суурилсан "Боловсролын салбарын хэтийн тооцоо 2020-2050 он" (https://moe.gov.mn/post/116608) судалгаа хийж, багшийн хэрэгцээг тогтоосон.

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний шинэчлэлтэй уялдаад шаардлагатай багшийн тоонд өөрчлөлт орох боломжтой.

Мэргэжлийн боловсролын хувьд 2020 онд Бодлогын судалгааны институц ТББ-аас хийсэн "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын эрэлтийн судалгаа"-аар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн тоо өсөх хандлагатай байна.

Хүснэгт 2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн тооны өсөлтийн урьдчилсан төлөв

№		2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
	Нийт шаардлагатай	4621	4709	4847	5017	5203	5454	5658	5867	6101	5989	6344
	Шинээр ажилд авах шаардлагатай	69	193	367	573	795	1082	1319	1567	1837	1761	2352

Багшийн хомсдолыг шийдвэрлэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яам нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" А/386 дугаар тушаал батлагдсан. Тушаалын дагуу:
  - сургуулийн захирал, сургалтын менежер 7 хоногт 6 хүртэл цагийн хичээл заах,
  - төгсөх курсийн оюутныг ерөнхий боловсролын сургуульд дагалдан багшаар ажиллах нөхцөл бүрдсэн.
- Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их Сургууль, "Гурван эрдэнэ" зэрэг багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын 3, 4 англиийн оюутнуудыг дагалдан /багшийн туслахаар/ ажиллуулж байна.

5. Боловсролын сайдын 2024 оны 7-р сарын 25-ны өдрийн А/06 тоот тушаалын талаар:


5.1.Боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргасан эсэх, дүгнэлтийг ирүүлнэ үү.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 176 дугаар тогтоолоор "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал" батлагдсан.

Хөтөлбөрийн шинэчлэлтэй суурь болгож дараах судалгаануудыг хийсэн.

1. Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үнэлэх үйл явцын тайлан
2. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл
3. Сургалтын хөтөлбөрт туссан чадамжийн шинжилгээ

Зураг 2. ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн чиглэлээр хийсэн судалгаа



Хөтөлбөрийн шинэчлэлийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, дүгнэлтээс:

Сургуулийн өмнөх боловсролын хувьд:

- Сургалтын чиглэл бүрээр эзэмших чадваруудыг тодорхойлж хүрэх үр дүнг тодорхой боловсруулан гаргасан нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болсон.

- нийгэмшихүй болон сургалтын 5 чиглэлийн 45 чадварууд нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээнд шууд болон дам туссан бөгөөд сургалтын хөтөлбөрт туссан чадваруудыг арга зүйгээр илүү дэмждэг,

- ЮНЕСКО-оос гаргасан бага насны хүүхдийг хөгжүүлэх чиглэлтэй сургалтын чиглэлийг харьцуулан авч үзэхэд, манай орны сургалтын хөтөлбөрт тусгасан чиглэлүүд агуулгын хувьд тохирч байна. Харин зарим нэгэн нэршлийн тухайд, тухайлбал, сурах арга барил ба танин мэдэхүй гэсэн чиглэлийг тусад нь томьёолж

аваагүй хэдий ч тухайн чиглэлд байгаа чадварууд нь нийгэмшихүйн зарим нэг нь чадвартай нийцэж байгаа

- Ёс суртахууны үнэт зүйл, нийгмийн харилцаа, зан үйл гэх чадварууд байхгүй байв. Энэ нь ардын уламжлал, ёс заншил гэсэн ойлголтыг дэмжсэн чадварууд дутмаг байгааг илрүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Бага боловсролын хувьд:

-Бага боловсролын түвшинд судалдаг хичээлүүдийн сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээний хэсэгт "ерөнхий" чадвар, чадамж туссан байдлыг илрүүлэх шинжилгээний үр дүнгээс бүх хичээлийн сургалтын хөтөлбөрт бие даан суралцах, хамтран суралцах чадвар туссан. Түүнчлэн хичээлүүдийн 90.9 хувьд харилцах, 81.8 хувьд үндэсний соёл, уламжлалыг хүндэтгэх, 72.7 хувьд асуудал шийдвэрлэх, сэтгэн бодох, 63.6 хувьд мэдээлэл, технологитой ажиллах, 54.5 хувьд байгаль орчинтой зөв харилцах, 45.5 хувьд эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болох чадвар, чадамж туссан байна.

-Бага боловсролын түвшинд судалж буй хичээлүүдийн 50-аас дээш хувийнх нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээний хэсэгт харилцах, хамтран болон бие даан суралцах чадвар туссан байгаагаас гадна агуулгад нь үндэсний соёл, уламжлалаа хүндэтгэх, мэдээлэл, технологитой ажиллах чадвар туссан байна.

-Сургалтын хөтөлбөрийн агуулгад хийсэн шинжилгээний үр дүнгээр математик, хүн ба орчин, монгол хэл, хүн ба нийгмийн сургалтын хөтөлбөрийн агуулгад танин мэдэхүйн чадварууд, монгол хэл, гадаад хэл, хүн ба орчин, иргэний ёс зүйн боловсрол, хүн ба нийгэм, хөгжмийн сургалтын хөтөлбөрийн агуулгад хэл-нийгэм харилцааны чадварууд, хүн ба орчин, математик, хүн ба нийгэм, биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн агуулгад бие бялдар, зан үйлийн чадвар, дадал бусад хичээлтэй харьцуулахад түлхүү туссан. Энэ нь математик, хүн ба орчин, хүн ба байгаль, англи хэлний боловсролын агуулга нь шинжлэх ухаан, технологи, гадаад хэлийг судлах хүсэл сонирхолтой болоход, монгол хэл, хүн ба нийгмийн боловсролын агуулга нь нийгмийн харилцааны бүхий л орчинд эх хэлээрээ чөлөөтэй харилцах, эх хэлээ дээдлэх, амьдран буй нийгмээ танин мэдэх, эх орныхоо түүх, соёлоор бахархах, өвлөн уламжилж хөгжүүлэх мэдлэг, ойлголт, хандлага, төлөвшилтэй болоход, урлаг (хөгжим, дүрслэх урлаг, технологи), биеийн

тамирын боловсролын агуулга нь бие бялдраа хөгжүүлэх, гоо сайхныг мэдрэх, шинийг санаачилж бүтээх, соёл өв уламжлалаа дээдлэх, ёс суртахуунтай байх мэдлэг, ойлголт, хандлага төлөвшилтэй болоход түс түс чиглэсэн байхыг сургалтын хөтөлбөрт дурдсантай тодорхой хэмжээгээр дүйж байна.

-Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаануудын үр дүнгүүд суралцагчид мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл мэдлэг, чадвараа хэрэглэх, ялангуяа, шинэ нөхцөлд хэрэглэх даалгаврын гүйцэтгэлээс илүү хувьтай байна. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн эхний нийтлэг хэсэгт олон улсын загварууд дахь чадвар, чадамжуудаас мэдээлэл, харилцааны технологийн чадвар, дасан зохицох, зөрчилдөөнийг шийдвэрлэх, эрсдэл хүлээх, бизнес сэтгэлгээ, дэлхийн иргэний талаарх мэдлэг, ойлголт, чөлөөт ардчилсан оролцоотой байх нь шууд тусаагүй байна.

-Олон улсын загварууд дахь чадвар, чадамжийг ангилсан ерөнхий хүрээгээр авч үзвэл, бага боловсролын сургалтын хөтөлбөрт хувь хүний, нийгмийн харилцааны, мэдлэг, мэдээллийн менежментийн чадварууд шууд туссан, харин дижитал бичиг үсгийн чадвар шууд тусаагүй, харин түүнийг хөгжүүлэхэд дэмжлэг болох чадварууд туссан байна.

Суурь боловсролын хувьд:

-Суурь боловсролын түвшинд судалж буй 19 хичээлүүдийн сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээнд шинжилгээ хийж үзэхэд 22% нь бүтээлч сэтгэлгээнд, 21% нь нийгэмшил, сэтгэл хөдлөлд, 24% нь хувь хүний хөгжилд, 14% нь мэдээллийн технологи хэрэглээнд, 19% нь Монгол ба дэлхийн иргэний чадварт туссан байна. Эндээс хувь хүний хөгжлийг дэмжсэн чадварууд өндөр хувьтай харагдаж байгаа бол мэдээллийн технологийн хэрэглээний болон монгол ба дэлхийн иргэний чадварын хувь бага байна.

-Сургалтын хөтөлбөрийн бүрдэл хэсэг түс бүрээр суралцагчдын эзэмших чадваруудын туссан байдлыг авч үзэхэд, агуулгад шууд байдлаар түлхүү туссан бол үнэлгээний хэсэгт харьцангуй бага туссан харагдаж байна. Харин сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, арга зүйд туссан байдал ойролцоо түвшинд байна.

-Сургалтын хөтөлбөрийн агуулгад хийсэн шинжилгээний үр дүнгээр монгол хэл, бичиг, математик, мэдээллийн технологи, физик, хими, биологи, түүх, газар зүй, дүрслэх урлаг, дизайн технологи, биеийн тамир, эрүүл мэнд, англи хэл, орос хэлний сургалтын хөтөлбөрийн агуулгад бүтээлч сэтгэлгээний чадварууд, монгол хэл, бичиг, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол, хөгжим, дизайн технологи, биеийн тамир, эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн агуулгад хэл-нийгэм харилцааны чадварууд, монгол хэл, бичиг, математик, мэдээллийн технологи, биологи, түүх, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол, иргэний ёс зүйн боловсрол, газар зүй, биеийн тамир, дүрслэх урлаг, дизайн технологийн сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийн чадварууд, математик, мэдээллийн технологи, хими, биологи, газар зүй, англи хэл, орос хэлний сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн хэрэглээний чадварууд, монгол хэл, бичиг, түүх, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол, дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөрт монгол ба дэлхийн иргэний чадварууд бусад хичээлтэй харьцуулахад түлхүү туссан байна. Энэ нь эх хэл болон гадаад хэлний агуулга нь суралцагчдын авьяас, чадварт тулгуурлан эх хэл, гадаад хэлийг сонирхон судлахад, математик, мэдээллийн технологи, байгалийн ухаан, түүх, нийгмийн ухааны агуулга нь шинжлэн судлах арга барил, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахих

соёлд суралцахад; урлаг, дизайн технологийн агуулга нь гоо зүй, ёс суртахууны соёл, үндэсний болон хүн төрөлхтний соёлын үнэт зүйлсэд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, бүтээлч эрэлхийллийн аргаар хөгжүүлэхэд, биеийн тамир, эрүүл мэндийн агуулга нь бие бялдар, эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болох, бусдын эрүүл мэндийн төлөө санаа тавих, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, ур чадвар эзэмшихэд тус тус чиглэсэн байхыг сургалтын хөтөлбөрт дурдсантай тодорхой хэмжээгээр дүйж байна

- Чадваруудыг нарийвчлан авч үзэхэд эргэцүүлэн бодох, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх, харилцах, бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх, багаар болон хамтарч ажиллах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадварууд өндөр хувьтай байгаа бол дасан зохицох, зохион байгуулах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, сэтгэл хөдлөлөө хянах чадварууд бага хувьтай гарсан байна. Цаашид чадваруудын тэнцвэртэй байдлыг хангах нь чухал бөгөөд мэдээллийн технологийн болон Монгол ба дэлхийн иргэний чадваруудыг судлагдахуун бүрийн онцлогтойгоор сургалтын хөтөлбөрт тусгах боломжийг эрэлхийлж, суралцагчдад эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй юм.

-Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаануудын үр дүнгүүдээс харахад суралцагчдын мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл харьцангуй өндөр боловч мэдлэг, чадвараа хэрэглэх, хэрэглээний даалгаврууудын гүйцэтгэл сул байна.

-Суурь боловсролын сургалтын хөтөлбөрт олон улсын загварууд дахь чадвар, чадамжийн туссан байдлыг авч үзвэл, бүтээлч сэтгэлгээний, хувь хүний хөгжлийн, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварууд түлхүү туссан, харин мэдээллийн технологийн хэрэглээний, Монгол ба дэлхийн иргэнийг хөгжүүлэхэд дэмжлэг болох чадварууд бага туссан байна.

Бүрэн дунд боловсролын хувьд:

-Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт бүтээлч сэтгэлгээний (бүтээлчээр сэтгэх, эргэцүүлэн бодох, асуудал шийдвэрлэх, зохион бүтээх) чадвар 25 хувийг, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн (харилцах, зохион байгуулах, сэтгэл хөдлөлөө хянах, удирдах, багаар болон хамтран ажиллах) чадвар 19 хувийг, хувь хүний хөгжлийн (бие даан суралцах, үүргээ ухамсарлах, хариуцлагатай байх, өөрийгөө хөгжүүлэх, хүлээцтэй, ёс суртахуунтай байх, дасан зохицох, хөдөлмөрч, хичээл зүтгэлтэй байх) чадвар 21 хувийг, мэдээллийн технологи хэрэглээний (мэдээлэл харилцааны технологиор мэдээлэл олж авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ёс суртахуунтай хэрэглэх) чадвар 17 хувийг, монгол ба дэлхийн иргэний (олон талт соёлын ойлгох, үндэсний онцлог, уламжлалт болон ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, оролцоонд тулгуурлан шийдвэр гаргах, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах) чадвар 18 хувийг тус тус эзэлж байна.

-Хэл хүмүүнлэгийн хичээлүүдэд нийгэмшил, сэтгэл хөдлөлийн, мэдээллийн технологи хэрэглээний чадвар, математик, мэдээлэл зүйн хичээлд бүтээлч сэтгэлгээний, хувь хүний хөгжлийн, мэдээллийн технологи хэрэглээний чадвар, нийгмийн ухааны хичээлүүдэд хувь хүний хөгжлийн, мэдээллийн технологи хэрэглээний, монгол ба дэлхийн иргэний чадвар, урлаг, гоо зүйн хичээлүүдэд бүтээлч сэтгэлгээний, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн, мэдээллийн технологи хэрэглээний чадвар түлхүү туссан байна.

-Бүрэн дүнд боловсролын ихэнх хичээлийн сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологи хэрэглээний (мэдээлэл харилцааны технологиор мэдээлэл олж авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ёс суртахуунтай хэрэглэх) чадварыг жигд тусгасан байна.

Иймд цаашид:

"Сургуулийн өмнөх боловсролын хувьд:

Манай улсын сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр нь хууль болон бусад бодлогын баримт бичигтэй уялдаатай боловсруулагдсан байна. Сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүд хоорондоо уялдаатай, бие биеэ дэмжсэн байгааг шинжилгээний үр дүнгээс харж болно. Мөн олон улсын зөвлөмжилсөн баримт бичигтэй харьцуулан шинжилж үзэхэд, нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн (ёс суртахууны үнэт зүйлс), сурах арга барил ба танин мэдэхүйн (сониуч зан, оролцоо, тууштай байдал, анхаарал, бие даасан байдал, санаачилга, хамтын ажиллагаа, бүтээлч байдал, үндэслэл, асуудлыг шийдвэрлэх, эрт үеийн шүүн тунгаах чадвар) гэсэн чадваруудыг өөрийн орны онцлог байдал, үндэсний соёл, өв уламжлалтай уялдуулан томьёолсон чадварыг цаашид тусгаж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Бага, дунд боловсролын хувьд:

Боловсролын тухай хууль, боловсролын бодлогын баримт бичгүүдийн заалт, олон улсын загварууд дахь нийтлэг чадамж зэргийг харгалзан монгол суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, дадлыг дараах 6 хүрээнд авч үзэж болохоор байна. Үүнд:

- Хувь хүний хөгжлийн
- Нийгмийн харилцааны
- Мэдлэг ба мэдээллийн
- Дижитал бичиг үсгийн
- Үндэсний үнэт зүйлсийн
- Тогтвортой хөгжлийн төлөөх боловсролын" зэрэг дүгнэлтүүд гарсан.

5.2. Боловсролын сайдын 2024 оны 07-р сарын 25-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтыг ирүүлнэ үү.

Албан бичигт хавсаргав.

5.3.Боловсролын сайдын 2024 оны 07-р сарын 25-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтаар байгуулагдсан ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын удирдамж, төлөвлөгөө гарсан уу? Гарсан бол ирүүлнэ үү.

Албан бичигт хавсаргав.

6. Багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулахтай холбоотой мэдээллийн талаар:

6.1. Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэж байна уу?

Хөдөлмөрийн тухай хуулийн 59.1-д "Ажил олгогч ажилтантай харилцан тохиролцсоны үндсэн дээр *аж ахуйн нэгж, байгууллага дотроо, харьяа нэгж,*

салбарын хооронд дараах үндэслэлээр ажилтныг гурван жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно" гэсэн зохицуулалт тусгагдсан байдаг.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-д "12.14.Терийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцон тухайн аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.", "12.15.Энэ хуулийн 12.14-т заасан багш, удирдах ажилтныг *шилжүүлэн ажиллуулах хугацаа, журмыг* боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасан.

Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу "Багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журам"-ын төслийг боловсруулж, батлуулахад бэлэн болсон.

6.2. Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах үндэслэл, шаардлага, гарах үр дүнг тайлбарлана уу?

Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу "Багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журам"-ын төсөлд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтантай өөртэй нь харилцан тохиролцсоны үндсэн дээр томилох эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн шилжүүлэн ажиллуулж болохоор тусгасан.

Ингэхдээ шилжүүлэн ажиллуулах багш, удирдах ажилтныг тухайн албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан туршлага; сургалтын байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг үндэслэн шилжүүлэн ажиллуулахаар тусгаад байна. Ингэснээр ижил түвшний албан тушаалын сул орон тоог нөхөх;.сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, ажлын үр дүн, гүйцэтгэлийг дээшлүүлэх; сайн туршлагаас суралцах нөхцөл боломж бүрдэх юм.

2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд нийт 1410 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан. Эдгээр боловсролын сургалтын байгууллагад нийт 1360 эрхлэгч ажиллаж байснаас 27% нь тухайн албан тушаалд 11-ээс дээш жил ажилласан туршлагатай байна. Мөн үндсэн багш нарын 21% нь багшаар 11-ээс дээш жил ажилласан байна.

2024 оны 08 дугаар сарын мэдээгээр ерөнхий боловсролын сургуулиудын 871 ерөнхий боловсролын сургуулийн 157 сургуулийн, үүнээс нийслэлийн 41, орон нутгийн 116 сургуулийн захирал тухайн албан тушаалд 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна.

6.3. Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах тохиолдолд тэдний нийгмийн хамгааллын асуудлыг өмнөх түвшнээс нь дордуулахгүй байх ямар зохицуулалтыг хийх вэ?

"Багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журам"-ын төсөлд:

- Багш, ажилтныг шилжүүлэн ажиллуулах тохиолдолд цалин, хөлс, хөдөлмөрийн нөхцөлийг дордуулахгүйгээр хүлээх эрх үүрэг, хариуцлага зэрэг асуудлаар харилцан тохиролцож гэрээ байгуулах,

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн, томилох эрх бүхий албан тушаалтан солигдсон нь шилжүүлэн ажиллуулах шийдвэрийг хугацаанаас өмнө цуцлах, шилжүүлэн ажиллуулах хугацаа дууссан багш,

удирдах ажилтныг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулахаас татгалзах үндэслэл болохгүй байх.

• Багш, удирдах ажилтан шилжин ажиллах хугацаанд шилжүүлсэн байгууллагад бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөний улмаас тухайн албан тушаалын орон тоо хасагдсан бол тухайн байгууллага нь урьд эрхэлж байсан албан тушаалтай нь адил чанарын өөр ажлын байраар хангах,

• Шилжин ажиллах тохиолдолд гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалтай холбоотой зэрэг зохицуулалтыг тусгасан.

Хавсралт 23 хуудастай.

Д.НАРАНБАЯР